

Дэлхийн Эдийн Засгийн өөрчлөлт, динамикийн онцлогууд, ойрын ирээдүйн төлөв

Ренчиннямын Амаржаргал^{*,1}, Цэдэвсүрэнгийн Даваадорж¹

^{*,1} Доктор (Ph. D) Монгол улсын 21 дэх Ерөнхий сайд, Санхүү эдийн засгийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дарга, Улаанбаатар хот, Монгол Улс

¹ Хүндэт профессор, доктор (Sc.D), Санхүү эдийн засгийн их сургуулийн Удирдах зөвлөлийн гишүүн, Улаанбаатар хот, Монгол Улс

*Corresponding author: amarjargal.r@ufe.edu.mn

Received: 28 February 2025 / Accepted: 21 March 2025 / published online: 01 May 2025

Түлхүүр үг: Эдийн засгийн өөрчлөлт, динамик, геополитика, инклюзив эдийн засаг

©2025, Author(s)



Хураангуй: Дэлхийн эдийн засаг ДНБ-ий тооцооллын өнөөгийн аргачлалаар тогтвортой хөгжлийн шатандаа шилжин орсон мэт харагдана. Гэвч дэлхийн эдийн засаг эдүгээ мөн л хүндрэлтэй, полиперма хямралд өртсөн бөгөөд өсөлт тэлэлтийн хурдац удааширах хандлагатай болсон хэмээн судлаачид дүгнэж байна. Үүнд дэлхийн улс гүрнүүдийн геополитикоос үндэслэлтэй эдийн засгийн гадаад орчны эрсдэлт нөхцөл байдал болон цаг уурын өөрчлөлтөөс хамаарах гамшигт үзэгдлүүд нөлөөлж буй. Энэхүү нөхцөл байдал ойрын ирээдүйд ч үргэлжлэх магадлалтай. Судлаачид эрдэмтэд, эдүгээ хүн нийгмийн амьдралд эдийн засгийн үйл ажиллагааны эерэг ба сөрөг нөлөөллийг ойлгомжтой, тодорхой болгох болон мэдээлэл, үзүүлэлтүүдийг бодит байдалтай тохируулах, эдийн засгийн тооцооллыг хялбарчлах зорилгоор инклюзив (бүтээмжтэй, өгөөжтэй, хүртээмжтэй) баялгийн эдийн засаг хэмээх шинэ ойлголт, парадигмыг боловсруулан дэвшүүлж байна.

World Economic Changes, Dynamic Features and the Near Future

Doctor (Ph.D), Professor Rinchenyam Amarjargal^{*,1}

^{*,1} 21st Prime Minister of Mongolia, Chairman of the Governing Body of the University of Finance and Economics. Ulaanbaatar, Mongolia.

Doctor (Sc.D), Distinguished professor Tsedevsuren Davaadorj¹

¹ Member of the Governing Board of the University of Finance and Economics. Ulaanbaatar, Mongolia.

Keywords: Economic change, dynamics, geopolitics, inclusive economy

Abstract

The world economy seems to have entered a stable development stage according to the current methodology for calculating GDP. However, researchers conclude that the world economy is still in a difficult and

poly-perma crisis, and the pace of growth and expansion is likely to slow down. This is due to the geopolitical risks of the world powers, the external economic environment, and catastrophic events related to climate change. This situation is likely to continue in the near future. Researchers and scientists are now developing and proposing a new concept and paradigm called inclusive (productive, profitable, accessible) wealth economy in order to clarify and clarify the positive and negative impacts of economic activity on human and social life, to adjust information and indicators to reality, and to simplify economic calculations.

I. УДИРДТГАЛ

Олон улсын санхүү, эдийн засгийн, мэдээллийн байгууллагуудын тооцоолсноор дэлхийн эдийн засаг 2024 онд 3 хувийн өсөлттэй гарах төлөвтэй. Дэлхийн эдийн засгийн өнөөгийн гадаад ба улс орнуудын макро эдийн засгийн дотоод орчин эдийн засгийн өсөлт хөгжилд нэн таатай бус, улс төр, геополитикийн нөлөөнд хэт автагдаж, глобализмын үеийн эдийн засгийн либерализмын хөшүүргүүд үйлчлэхгүй болж, улс орнууд эсрэг тэсрэг сонирхолтой бүлгүүд, блокууд болон хуваагдах чиг хандлага ажиглагдана.

Улс орнуудын хоорондын эдийн засгийн тогтвортой харилцаа, чөлөөт худалдаа үлэмжхэн хумигдаж, уламжлалт эдийн засгийн гинжин хэлхээ холбоо тасарч, олон улсын хөдөлмөрийн хуваарилалтад тулгуурласан туйлын ба харьцангуй давуу талыг ашиглах боломжоо алдахад хүрлээ. Өөрөөр хэлбэл энэ цаг үеийн алдагдсан боломжийн нөхцөл байдал үлэмжхэн гүнзгийрчээ. Энэ нь зарим улс оронд, ялангуяа хөгжиж буй орнуудад инновацид тулгуурласан үйлдвэрлэлийг амьдралд нэвтрүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд саад болж, хоцрогдлыг улам гүнзгийрүүлж буй нь ойлгомжтой.

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүд сүүлийн 10 жилд өмнөх арван жилийнхээс дордсоныг статистик мэдээллүүдээс ажиглаж болно. Статистик мэдээлэлд дурдсанаар бол дэлхийн эдийн засгийн өсөлт 2010-2020 онд дунджаар жилд 2.7% болон буурчээ. Гэхдээ энэ нь абсолют үзүүлэлтүүдэд хараахан нөлөөлөхгүй бөгөөд дэлхий нийтийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 онд 66.6 триллион доллар байснаа 2023 онд 105.1 триллион доллар болон өсжээ (World Bank Group, 2024).

Эдүгээ дэлхийн ДНБ-ий үйлдвэрлэлд өндөр хөгжилтэй буюу өндөр орлоготой орнууд 60 гаруй хувийг эзлэдэг гэсэн үзүүлэлт, баримт байдаг. Харамсалтай нь, хөгжиж буй орнуудын сүүлчийн 10 жилийн эдийн засгийн динамикийн үзүүлэлтүүд нь мөн л хангалттай бус, үлэмжхэн багассан, саарсан дүнтэй. 2000-2010 оны арван жилд бага ба дундаас доогуур орлоготой орнуудын эдийн засгийн өсөлт жилд дунджаар 1.2 хувиар саарсан ба дундаас дээш орлоготой орнуудынх 2.3 хувиар доошилсон гэсэн дүн гарчээ (World Bank Group, 2024).

Гэхдээ эдийн засгийн хөгжил дэвшил, өсөлт хэмээх ойлголт нь өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын онцлогоос шалтгаалан практик амьдрал дээр өвөрмөц

хэлбэрүүдээр илэрнэ. Хөгжиж буй орнуудын хувьд бол гадаад эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцох, хотжилт, түүнтэй холбоо бүхий үйл ажиллагаа, зам тээврийн болон бусад дэд бүтцүүдийг хөгжүүлэх, хүнсний бүтээгдэхүүнийхээ нийлүүлэлтийг хэвийн болгох нь ойрын ирээдүйн хөгжил дэвшлийн гол зорилго байх болно. Дэлхий даяар эдгээр асуудлыг шийдвэрлэсэн үлэмжхэн туршлага, нөөц бололцоо байгаа боловч тэдгээрийг хөгжиж буй орнуудад хэрэгжүүлэхэд цаг үеэ олсон, бодит туслалцаа үзүүлэх боломж хомс байгаа нь нэн харамсалтай.

Дэлхийн банкны тайлангаас үзвэл, 2024 онд дэлхийн худалдааны өсөлт цар тахлаас өмнөх 10 жилийн дундаж үзүүлэлтээс буурах төлөвтэй ажээ. Дэлхийн эдийн засгийн өсөлт, тэлэлтийн удаашрал нь хөгжиж буй хоцрогдсон орнууд, тэдгээрийн ядуулаг, үгээгүй иргэдэд асар хүнд цохилт болж хувирав. Дэлхийн банкны тэмдэглэж буйгаар бол “2030 он хүртэлх хугацаанд хэт ядуурлыг багасгах талаар дэлхий нийтээр зохиож эхэлсэн ажил зогслоо”, улс орнуудын эдийн засгийн тэгш бус байдал, зарим хөгжиж буй орнуудын ядуурал дэлхийн II дайнаас хойших жилүүдийн хамгийн доод түвшинд хүрснийг мөн анхааруулжээ.

Эдүгээ дэлхийн ихэнх улс орнуудын гадаад ба дотоод орчны нэн хүндрэлтэй байдал нь дэлхийн эдийн засагт улс төрийн ба институцийн эдийн засгийн хэлбэрүүдээр үлэмжхэн нөлөөлөх болж үндэсний эдийн засгуудад бүтцийн томоохон өөрчлөлт гарч байгаа үзэгдлүүдээр тайлбарлагдана.

II. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ДИНАМИКИЙН ОНЦЛОГУУД, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

Дэлхийн улс гүрнүүдийн хөгжил, харилцааны явцад геополитикийг идэвхтэй бөгөөд эрчимжсэн хэлбэрээр хэрэгжүүлэх олон хөшүүрэг, хүчин зүйлүүд байдаг боловч эдийн засгийн хүрээнд ихэвчлэн экспортыг өрөөсгөл хэлбэрээр нэмэгдүүлэх хандлагаар илэрхийлэгдэх болжээ. Сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засагт үлэмжхэн нөлөөтэй Хятадын эдийн засаг хүндрэлтэй нөхцөл, орчинд автагдсаныг олон судлаач, шинжээч тэмдэглэжээ. Даниел Х.Розен ба Логан Райн нарын судалгаагаар Хятадын эдийн засаг 2010-2019 онд дунджаар жилд 7.7 хувийн өсөлттэй байсан бөгөөд дунд зэргийн хөгжилтэй орны статусыг хангаж чаджээ. Харин сүүлийн жилүүдэд Хятадын эдийн засгийн өсөлт удааших хандлагатай болсон бөгөөд экспорт нь импортоос 1.7 триллион доллараар давж, худалдааны балансын асар их профициттэй болжээ (Daniel H. Rosen, 2023). Өнгөц харахад энэ үзүүлэлт нь эдийн засгийн том амжилт мэт харагдавч дээрх шинжээчдийн тэмдэглэснээр Хятад улс макро эдийн засгийнхаа нийт эрэлтийг дэмжих бодлогоо орхигдуулж, дотоодынхоо хэрэглээнд анхаарлаа хандуулаагүй явдал сүүлийн үеийн эдийн засгийн хүндрэлийн гол шалтгаан болсон ажээ.

Макро эдийн засгийн нийт эрэлтийг зохистой хэмжээнд хүргэж чадаагүй нөхцөлд бизнес нэгжүүд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ дотоодын, эх орныхоо, ард иргэдийнхээ хэрэглээнд зориулан худалдаж борлуулах боломжгүй болж, дотоодын эдийн засгийн орчил эргэлтийг зогсонги байдалд оруулах нэн эрсдэлтэй зам руу шилждэг жамтай ажээ. Ер нь экспортыг зохистой хэмжээнээс хэтрүүлэн, ялангуяа импортоос үлэмжхэн хэмжээнээр давуулан геополитикийн гол хэлбэр, биеэ даасан зорилт болгон өргөжүүлэх нь бусад орны итгэл найдварыг алдаж, өөрийнхөө сонирхлын эсрэг

хандуулж болох улс төрийн сөрөг нөлөөтэй. Сүүлийн үеийн мэдээллүүдээс үзвэл, Хятад улс экспортын хэмжээгээ нэмэгдүүлсээр байгаа болон асар их илүүдэл хүчин чадалтай болжээ.

Дээрх эрдэмтдийн судалгаанаас үзэхэд эдийн засгийн хөгжлийн түүхэнд Япон улс 1970-1980-аад онд худалдааны дисбаланстай байсан бөгөөд үүнийгээ хойшид ч үргэлжлүүлэх сонирхолтой байжээ. Гэвч 1984-1985 онд Америкийн санаачлагаар Япон улстай гэрээ хэлэлцээр хийх замаар худалдааны дисбаланс аль ч талд үр ашиггүй гэдгийг ойлгуулсан гэдэг. 1985 онд Япон улс “Плаза”-ийн ба “Луврын” нэгдэж, өөрийнхөө экспортыг хязгаарлан, бүтцийн өөрчлөлтийг хийж, үндэсний эдийн засгаа хөгжүүлэх нэмэгдэл потенциалтай болсон түүхтэй.

Пермакризисийн онцлог бол уг хямралыг өдүүлсэн нөхцөл байдал бүрэн устаж үгүй болдоггүй, тодорхой хугацааны дараагаар олон дахин давтагдах эрсдэлтэйн зэрэгцээгээр, түүнтэй тэмцэхэд байнгын хүч хөрөнгө, зардал гардагт оршино. Энэ жил л гэхэд цар тахлын үед үйлдвэрлэсэн бөгөөд одоо хугацаа нь өнгөрсөн вакцинуудыг устгахад олон миллиард долларын зардал гарч байгаа бөгөөд дараагийн тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор мөн л олон миллиард долларын вакцин үйлдвэрлэх шаардлагатай. Мөн улс орнуудын үндэсний эдийн засгийн бүтцийг геополитикийн нөхцөл байдалтай тохируулан байнга өөрчлөх бодит шаардлагатай тулгарсныг тэмдэглүүштэй.

Дэлхийн хөгжингүй олон улс гүрнүүдийн үндэсний эдийн засагт ч бүтцийн өөрчлөлтийг цаг алдалгүй тодорхой нөхцөл байдалдаа тохируулан тогтмол, байнга хийх бодит шаардлага үүссэн тул үүнд зарцуулах хөрөнгө мөнгө, санхүү ихээхэн хэмжээгээр өсөж эдийн засгийн ерөнхий хөгжил дэвшил, өсөлтийн хурдац удаашрах хандлага ажиглагдана.

Нэн түгшүүртэй мэдээлэл бол хөгжингүй зарим орнуудын хүн ам хөгшрөх хандлагатай болж хүн амын өсөлт мөн удааширч, хүн ам зүйн нөхцөл байдал муудах хандлагатай болжээ.

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар эдийн засгийн өндөр хөгжилтэй, хүчирхэг орнуудад ч иргэдийн доторх орлогын тэгш бус байдал гүнзгийрч, баян ядуугийн зөрүү ихсэх хандлагатай болжээ. Оксфамын мэдээлснээр, 2020 оны байдлаар дэлхийн хамгийн баян 1 хувь хүмүүс 42 триллион долларын баялаг эзэмшдэг бөгөөд энэ нь бусад 99 хувьд ногдох баялгаас гэсэн тооцоо гарчээ. Давост болсон чуулганы үеэр дэлхийн баячуудын баялаг ба хэт ядуучуудын тоо сүүлийн 25 жил зэрэгцэн нэмэгдсэн таатай бус мэдээллийг дахин дурдсан билээ. 2022 онд хүнсний ба эрчим хүчний томоохон 95 корпораци 306 тэрбум долларын ашиг олж, түүнээсээ 257 тэрбумыг (84 хувийг) баян хувь нийлүүлэгчдэдээ хуваарилжээ. Томоохон корпорациудын олсон хэт их ашиг нь Австрали, Америк, Английн өндөр инфляцийг өдүүлсэн нэгэн хүчин зүйл болсон гэж үздэг. Нөгөө талаар хөгжингүй орнуудын төр засаг болон дундаж иргэдийн санхүүгийн байдал нэлээд доройтсон учир нийт өрийн хэмжээ мөн л өсөх хандлагатай болжээ. Мэдээж, өр зээлийн дарамтад иргэдийн ядуулаг буюу олонх хэсэг нь илүү өртөх магадлалтай.

Энэхүү байдлаас үндэслэн дэлхийн бараг бүх улс орнуудын макро эдийн засгийн дотоод орчил эргэлтэнд томоохон өөрчлөлт гарах төлөвтэй.

Зах зээлийн эдийн засгийг өрнүүлэх чухал гол хүчин зүйл болох нийт иргэдийн хэрэглээний зардал нь баячуудынх ба бусад иргэдийнх гэсэн тусгаарлагдмал хоёр хэсэг болон хуваагдаж, худалдан авах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний бүтцүүд мөн эрс ялгаатай болжээ. Баячуудын орлогын эх үүсвэр болон хэрэглэх бараа таваар, үйлчилгээ нь бусад иргэдийнхээс эрс өөр байх учир орлого, зардлын урсгал нь ч хүн амын нөгөө, дийлэнх хэсгийнхээс өөр, өвөрмөц бүтэцтэй, бүрэн биеэ даасан орчил эргэлт хэлбэрээр хэрэгжих болжээ. Жишээ болгон дурдахад, саяхан Америкт мэдрэлийн системийн өвчлөлийг эдгээх эм шинээр гарсан бөгөөд түүний үнэ нь 4.5 сая доллар болсон ажээ. Энэ хэлбэрээр, нэг улс орны нэгдмэл байх ёстой макро эдийн засгийн орчил эргэлт нь хоёр хэсэгт хуваагджээ.

Үүний зэрэгцээгээр дайны эдийн засаг, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан гамшигт үзэгдлүүдтэй тэмцэх, түүний хор нөлөөг устгах арилгахад гарч буй зардлууд ихэнх төлөвдөө засаг төрийн төсвөөр, төрийн хэрэглээ хэлбэрээр санхүүжигдэх болжээ. Энэ нь татвар, хураамжаар ихэвчлэн бүрэлдэх улсын төсвийн орлого ба зардлын урсгалыг үлэмжхэн нэмэгдүүлж макро эдийн засгийн томоохон бөгөөд мөн л харьцангуй тусгаарлагдмал орчил эргэлт хэлбэрээр хэрэгжих болов.

Энэхүү макро эдийн засгийн орчил эргэлт нь томоохон, хүчирхэг, ихэвчлэн инновацад суурилсан бизнес нэгжүүд, тэдгээрт хөрөнгө оруулагч баячууд болон засаг төрийн хооронд үүсэх эдийн засгийн үйл ажиллагааны харилцааны хэлбэр бөгөөд жирийн иргэдийн оролцоогүйгээр хэрэгжих тул мөн л улс орны эдийн засгийн ардчиллыг хумиж, хүн нийгмийн эдийн засгийн үйл ажиллагааны эцсийн үр дүнг сааруулж буй нийтлэг үзэгдэл болон хувирч буйг тэмдэглүүштэй.

Энэхүү макро эдийн засгийн өвөрмөц орчил эргэлт нь цар хүрээний хувьд ойрын ирээдүйд улам өргөжих хандлагатай тул улс гүрний эдийн засгийн хөгжлийн хурдцыг сааруулах, удаашруулах хүчин зүйл хэвээр байх болно.

Эдгээр нөхцөл байдлын зэрэгцээгээр цэрэг дайны явцад учирсан хохирол болон цаг уурын өөрчлөлтөөс үүссэн томоохон гай гамшгийн хор нөлөөг арилгахад зориулсан хөрөнгө зардлыг бодолцон баримжаалан тооцоолбол дэлхий нийтийн улс орнуудын өнөөгийн эдийн засгийн үйл ажиллагааны эцсийн үр дүн болон хүн нийгмийн нийт баялгийн цар хүрээ, абсолют хэмжээ нь сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдээгүй ч байх магадлалтай.

Дэлхийн эрчим хүчний агентлагын судалгаанаас үзвэл, дэлхийн дулаарлыг 1.5°C нэмэгдэх хэр хэмжээгээр хязгаарлах хувилбарыг хэрэгжүүлэхэд жил бүр 5.3 триллион долларын хөрөнгө оруулалт шаардагдах тооцоо гарсан байдаг.

Эдүгээгийн дэлхийн эдийн засгийн өсөлтийн удаашрал, полипермакризисийн өдөөсөн томоохон хүчин зүйл бол дэлхийн олон өнцөг хэсэгт өрнөсөн цэрэг дайны үйл ажиллагаа байнгын хэлбэрт шилжиж, цэрэг дайны хөнөөлт эдийн засаг өргөжих хандлагатай болсон явдал мөн.

Дайны эдийн засгийн талаарх мэдээлэл нэн дутмаг, ихэнх төлөвдөө хаалттай бөгөөд, хүн нийгэмд хүртээмжгүй хэвээрээ байгаа тул хүмүүс, иргэд зөвхөн асар их хор хөнөөлтэй гэдгийг л төсөөлдөг. Энэхүү байдлыг дайн өдөөсөн орнуудын улс төрийн дээд удирдлага, элитүүд овжин ашиглаж, дайны эдийн засаг улс орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлдэг гэсэн утгатай суртал ухуулгыг нэвтрүүлсээр.

Орос улс өөрийнхөө өдөөсөн цэрэг дайны үйл ажиллагааг эдийн засгийн өгөөж, үр дүнгийн хувьд өндрөөр үнэлж, дотоодын эдийн засагтаа хор хөнөөл учруулаагүй, харин Оросын эдийн засгийн өсөлтийг тогтворжуулсан хэмээн зарлаж байна.

Олон улсын валютын сан Оросын эдийн засгийн тогтвортой байдлыг хүлээн зөвшөөрч, энэ оны өсөлтийн таамаглалыг 1,1%-аас 2,6% болгон нэмэгдүүлсэн тооцоо ч гарчээ. Блюмбергийн мэдээллийн хөтөлбөр ч Оросын дайны эдийн засгийн үзүүлэлтүүд өндөр үр дүнтэй мэт, нэмэгдэл тайлбар, судалгааны дүгнэлтгүйгээр мэдээллийг дамжуулсаар байгаа нь хүн нийгэмд буруу, ташаа ойлголт төрүүлэх аюултай.

Бодит амьдрал дээр бол дайны эдийн засаг ялангуяа цэрэг дайны ажиллагаа нь дайн эхлүүлж, өдүүлсэн орны үндэсний эдийн засагт үлэмжхэн хор хөнөөл авчрахын зэрэгцээгээр дайнд өртсөн орны эдийн засгийг ч бусниулах хор нөлөөтэй. Харин сүүлийн үед, энэ оны 3 дугаар сараас эхлэн дайны эдийн засгийн хор хөнөөлийн талаарх мэдээллүүд олшрох хандлагатай болжээ.

Орос орны хувьд дээр дурдсан эдийн засгийн тоо баримтууд үнэн боловч өнөөгийн дэлхий даяар хэрэглэж буй үндэсний тооцооллын өрөөсгөл илэрхийллээс (зөвхөн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд нөлөөлөх тооцоог харуулдаг, хор хохирлын тооцоог орхигдуулдаг аргачлалыг ашигладаг) үлэмжхэн шалтгаалсан бөгөөд цэрэг дайны явцад улс оронд тулгарах хамгийн том аюул цэргүүдийнхээ, ард иргэдийнхээ үхэл эрсдэлийг болон эх орноосоо дүрвэгсдийн тоог бодолцохгүйгээр дэлхий нийтэд, өөрийнхөө ард түмэнд зарласан төөрөгдөл тооцооны хэлбэр юм.

Нөгөө талаар цэрэг дайны эдийн засаг нь дайчилгааны хэлбэрээр хэрэгжих тул зөвхөн дайны зориулалттай зэр зэвсгийг үйлдвэрлэх аж үйлдвэрийн ба эрчим хүчний салбаруудыг түлхүү, түргэн өргөтгөдөг. Үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд бусад эдийн засаг, салбаруудыг орхигдуулдаг жамтай. Зарим нөхцөлд инновацыг түргэн нэвтрүүдэг туршлага ч байдаг. Дайчилгааны эдийн засаг, цэрэг дайны үйл ажиллагаа үргэлжилж буй үед хямд үнээр цэрэг дайны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой байдаг. Оросын тэрбумтан М.Ходорковский Берлинд болсон бага хурал дээр Орост их буны нэг сумыг үйлдвэрлэхэд 500 доллар зарцуулдаг бол барууныхан 5000-8000 долларын зардал гаргадаг хэмээн жишээ болгон дурджээ.

Санхүү ба бусад ресурсийн нэн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цэрэг дайны эдийн засгийг ихэвчлэн улсын төсвөөс санхүүжүүдэг ганцхан эх үүсвэртэй байдаг тул зөвхөн богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой гэдгийг тэмдэглүүштэй. Оксфордын их сургуулийн профессор М.Рохлин “Дайны дараа Оросын эдийн засаг сүйрнэ”, Оросын зэвсгийн үйлдвэрлэлийн өсөлт нь эдийн засагт эерэг хүчин зүйл болж байгаа мэт харагдавч энэ нь ирээдүйтэй хөрөнгө оруулалт биш бөгөөд дайн дуусахад ийм эдийн засаг сүйрнэ” гэж тэмдэглэжээ.

Шинжээчид Оросын эдийн засаг чадварынхаа хязгаарт хүрч, үүнээс цааш “хэт халалт энэ өсөлтийг үргэлжлүүлэх боломжгүй болгоно” гэсэн дүгнэлт хийжээ. Эдийн засгийн ухаанд “хэт халалтыг” ихэвчлэн стагнаци гэж томъёолдог бөгөөд энэ нь тодорхой хугацааны дараа зогсонги байдалд орох үзэгдлийн нэршил юм.

Дайны эдийн засгийн үед үйлдвэрлэсэн цэргийн бүтээгдэхүүнүүд, цэрэг дайны зэр зэвсгүүд (нисэх онгоц, далайн хөлгүүд, танк, машин, их буу болон тэсрэх дэлбэрэх хэрэгслүүд, бууны сумнууд) бүгдээрээ жирийн хүмүүсийн амьдрал хэрэглээнээс гадуур, холуур дайны талбар дээр бүрэн устаж үгүй болох тавилантай учир улс нийгмийн жинхэнэ баялгаас эрс ялгаатай, баялаг болон ард нийтийн хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгсэл бус үргүй хоосон, хөдөлмөр, зардлын хэлбэр. Эдгээр бүтээгдэхүүнийг дайны талбар дээр буюу дайнд өртсөн орны нийгмийн баялгийг устгах, сүйтгэх зориулалттай үйлдвэрлэсэн учир хүн нийгэмд давхар хохирол сүйтгэлийг учруулна. Хүн нийгэмд дайны эдийн засгийн хамгийн их хөнөөл хохирол учруулах хорт нөлөөлөл нь хөдөлмөрийн насны олон хүмүүс эрсдэж, үхэж үрэгддэгийг үнэлж тооцоолох ямар ч утга, аргагүй. Дайны буюу дайчилгааны эдийн засгийн үед дайнд хамрагдсан орнуудын олон иргэн эх орноосоо дайжиж, гадагш цагаачлан нүүдэллэж хүн ам зүйн хувьд үлэмжхэн хохиролд нэрвэгдэнэ.

Энэ тухай хэвлэлүүдийн мэдээлснээр, Оросын арми тусгай албадын зардал улсын төсвийн 40 орчим хувийг эзлэх болжээ. Энэ нь яваандаа нийгмийн бусад зардлыг танах, ард олны амьдралын түвшнийг эрс доошлуулах хөнөөлт үйл ажиллагаа болж хувирна. Украйны хувьд бол дайнд шууд өртсөн бөгөөд дийлдэшгүй зэрэглэлийн гадаад хүчин нөхцөлд автагдсан бөгөөд нийгмийн баялаг, хувь хүмүүсийн хөрөнгө, эд хогшил, орон барилгаа сүйтгүүлсэн сэтгэл санааны гай зовлонд нэрвэгдсэн орон болжээ.

Мөн байлдаанд өртсөн орнуудад дэлхийн бусад орнуудаас үлэмжхэн хэмжээний байлдааны хэрэгслүүдийн болон санхүүгийн тусламжийг үзүүлж буй нь эдийн засгийн утга агуулга талаас авч үзвэл үргүй зардлын томоохон илрэл мөн боловч шинэ хэлбэрийн улс төрийн эдийн засгийн, ялангуяа геополитикийн эдийн засгийн бүрэлдэхүүн хэсэг болж пермакризисийн гүнзгийрэн дэлгэрэх нөхцөл болон хувирах төлөвтэй. Мөн дайн байлдааны үйл ажиллагааг шууд эхлээгүй боловч цэрэг дайны бэлтгэл ажиллагаа хэмээгч шинэ төрлийн эдийн засаг, зах зээл өргөжих хандлагатай болжээ.

Эдгээр бүх төрлийн эдийн засаг нь энх тайвны үеийн буюу ердийн эдийн засгаас үлэмжхэн ялгаатай бөгөөд ихэвчлэн улс төрийн, геополитикийн шууд үр дүн бөгөөд эцэстээ, дэлхий даяар эдийн засгийн хөгжил, өсөлтийг удаашруулах сөрөг хүчин зүйл болон хувирч, полиперманент хямралыг гүнзгийрүүлэх аюултай.

Цэрэг дайны үйл ажиллагаатай холбоотой бөгөөд хямралт байдлыг үүсгэгч өөр нэгэн хөнөөлт үзэгдэл бол ядуу, дорой эдийн засаг бүхий жижиг орнуудад цэргийн дээд эрхтнүүд төрийн эргэлт хийх замаар засгийн эрхийг булаан авч өөрийнхөө иргэдийг төрсөн нутаг, эх орноосоо дүрвэж зугтах хүртэл дарангуйлах нөхцөлийг бүрдүүлж буй нь нэн харамсалтай.

Цэрэг дайны үйл ажиллагаа хэзээ нэгэн цагт дуусч, энхийн амьдрал эхлэх цаг үед сэргээн босголтын үе хэмээх асар их цар хүрээтэй, өндөр өртөг, зардал бүхий энхийн амьдрал ирээдүйд олон жил үргэлжлэх учир, улс орны эдийн засаг өсөж хөгжих бус,

харин алдагдаж сүйтсэн баялагаа нөхөх, эрүүл мэндээ сэргээх, сэтгэл санааны зовлон хохирлоо нөхөх, өнгөрсөн үе, цаг мөчийн эдийн засаг, амьдралын түвшнээ сэргээх томоохон ажиллагаа эхэлдэг жамтай.

Дэлхийн эдийн засагт үлэмжхэн сөрөг нөлөө үзүүлж буй бөгөөд бараг дийлдэшгүй, давагдагдашгүй нөхцөлийн зэрэглэлд хамаарагдах хүчин зүйл: цаг уурын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөлөл, байгалийн гамшигт үзэгдлүүдийн давтамж олширч буй болон тэдгээрийн учруулсан хохирол, хөнөөл, сөрөг үр дагаврыг арилгах, багасгахад чиглэгдсэн үйл ажиллагаа үлэмжхэн өргөжих хандлагатай боллоо.

Гэтэл цаг уурын өөрчлөлтөөс шууд хамааралтай эдийн засгийн хохирол хөнөөлийг нэгтгэн үнэлж, тэдгээрийн сөрөг үр дагаврыг арилгах багасгахад чиглэсэн ихээхэн хөрөнгө мөнгө, хөдөлмөрийг тооцоолох ажиллагаа, аргачлал бодит амьдралаас үлэмжхэн хоцрогдсоныг тэмдэглүүштэй.

Газар хөдлөлтөөс шалтгаалан хүмүүсийн орон сууц, барилга байшин нурж, цунами, аадар борооны улмаас хөрсний гулгалт болж, олон хүн амь эрсдэж, зарим газар нутагт ган гачиг, зуд нүүрлэж хөдөө аж ахуйн салбар үлэмжхэн хохирол амсаж байгаа зэргийг бүрэн хэмжээгээр үнэлэх шаардлага өргөжлөө. Ялангуяа эдгээр хохирлыг багасгах, арилгах үйл ажиллагаанд зарцуулсан мөнгө, хөрөнгө, хөдөлмөрийн статистик бүртгэл, тооцоог боловсронгуй болгох, нийгэмд зөв ойлгуулах талаарх эдийн засгийн онол практикийн ажиллагаанд анхаарлаа хандуулах цаг мөчтэй тулгарлаа.

Өнөөгийн практик тооцооллоор бол цаг уурын гамшигт үзэгдлүүдтэй тэмцэхэд зориулсан зардал нь улс орнуудын зөвхөн зохион байгуулалттай, төрийн шууд дэмжлэгээр оролцсон аж ахуйн нэгжүүдийн зарцуулсан хөрөнгө мөнгө, хөдөлмөрийн хэмжээгээр хязгаарлагдаж байгаа бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа нь шинээр бүтээсэн, үйлдвэрлэсэн утга агуулгатай болж хувирахын зэрэгцээгээр эерэг үзэгдэл мэт үнэлэгдэж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн үзүүлэлтэд хамрагдаж буй нь тун гайхалтай.

Цаг уурын өөрчлөлт, дулаарлаас шалтгаалан дэлхийн улс нийгмийн эдийн засагт сөргөөр нөлөөлж, өнөөгийн хямралт байдлыг гүнзгийрүүлж буй өөр нэгэн үйл ажиллагаа бол эрчим хүчний бүтцийг огцом, богино хугацаанд өөрчлөх зорилготой буюу нүүрс хүчлийн давхар ислийг ялгаруулагч дулааны цахилгаан станцуудын ажиллагааг зогсоож, ногоон эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд зориулсан зардлууд үлэмжхэн өсөж, эдийн засагт томоохон “ногоон” ачаалал, дарамт хэлбэрээр илэрч буй нийтлэг үзэгдэл юм.

Эдгээр зардал нь цар тахлаас хойших цаг үетэй ихэнх төлөвдөө давхацсан бөгөөд байнгын хямрал үүсгэх хүчин зүйл болж хувирчээ. Цэвэр буюу ногоон эрчим хүчний салбарыг бүрдүүлэхэд зориулсан бөгөөд зөвхөн 2023 онд гарсан хөрөнгө оруулалт, зардлууд нь 1,7 их наяд долларт хүрчээ.

Олон улсын эрчим хүчний агентлагын тооцоогоор нүүрсхүчлийн хийн ялгарлыг тэглэх зорилгыг хэрэгжүүлэхэд 2030 он хүртэл бараг 40 их наяд долларын хөрөнгө шаардагдах ажээ. Гэхдээ, эдгээр ажил дэлхийн улс орнуудын дунд жигд бус хэрэгжиж байгаа бөгөөд эрчим хүчний хуучин салбаруудын хөрөнгө оруулалт эрс багасаагүй, харин ч 2023 онд бараг 8 хувиар нэмэгдэж, үүний дийлэнхийг Хятад болон Энэтхэг улсын чулуун нүүрсний хэрэглээ нэмэгдсэнээр илэрхийлэгдэнэ.

III. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ОЙРЫН ИРЭЭДҮЙН ТӨЛӨВ

Дэлхийн эдийн засгийн ойрын ирээдүйн динамикийн ерөнхий төлөв нь өмнөх жилүүдтэй төстэй бөгөөд улс төр, геополитикийн нөлөөллөөс үлэмжхэн хамааралтай, дайн байлдааны зөрчил тэмцэлдээн үргэлжилсэн, цаг уурын өөрчлөлтийн аюулт үзэгдлүүдийн давтамж ихэссэн, хор нөлөө нь үлэмжхэн өссөн, нэн эгзэгтэй, тодорхой бус байдлаар илэрхийлэгдэх нь ээ.

Эдүгээгийн дэлхий даяарх улс төр, геополитикийн бодлогын давамгайлал нь эдийн засгийн хувьд нэн таатай бус орчныг үүсгэх бөгөөд нэлээд удаан хугацаагаар үргэлжлэх төлөвтэй. Дэлхийн эдийн засгийн гол зураглал нь өсөлт, хөгжлийн хурдац зогсонги байдалд орох хандлагын зэрэгцээгээр гол утга, мөн чанарын хувьд хүн нийгмийн соёл иргэншлийн гол үнэ цэнт чанар: ардчилал, тэгш байдлыг хангах чадваргүй болсоноор илэрхийлэгдэнэ.

Дэлхийн эдийн засгийн байгууллагууд: Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн тооцооллоор 2025, 2026 онд дэлхийн эдийн засаг 2,7-3,2 хувиар өсөх магадлалтай ажээ.

Дэлхийн эдийн засаг гол бүтцийн хувьд баян улс гүрнүүд ба хоцрогдсон дорой орнууд хэмээн дотроо үлэмжхэн ялгаатай хэвээр байх ба мөн улс гүрнүүдийн иргэд ч дотроо баячууд ба үгээгүйчүүд, дундчуул хэмээх эсрэг тэсрэг сонирхолтой бүлэг, хэсгүүд байх болно. Энэ нь дэлхийн улс гүрнүүдийн улс төрийн элитүүдийн үйлдэл, шийдвэрийн суурь үндэс болж буй тул энэхүү зөрчилтэй нөхцөлд боловсрогдсон улс төрийн бодлого, шийдэл зөв зүйтэй болсон гэхэд эргэлзээтэй бөгөөд ялангуяа түүнийг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх үндэслэл нэн хомс.

Улс гүрнүүдийн дотоодын эдийн засгийн орчинд либерализм хумигдах хандлагатай болсон бөгөөд нэгдмэл бүтэцтэй байх шаардлагатай макро эдийн засгууд дотроо элитийн (баячуудын) ба жирийн ядуулаг иргэдийн болон мөн төрийн эдийн засгийн орчил эргэлтүүдэд хуваагдсан нь нийгмийн энх амгалан, жаргалтай, эв нэгдэл нягтралтай амьдралыг төвхнүүлэхэд саад эрсдэл үзүүлсэн хэвээр байх болно.

Дэлхийн улс гүрнүүдийн иргэдийн жаргалтай амьдралын индексийн үзүүлэлтэд тэргүүлэх байр суурийг эдийн засгийн хүчирхэг баян улс орнууд эзлээгүй, харин улс төрийн ухаалаг удирдлага, элитүүдтэй жижиг орнууд эзэлснийг тэмдэглүүштэй. Эдгээр байдлаас үндэслэн дэлхийн эдийн засгийн судалгааны байгууллагууд болон эрдэмтэд улс гүрнүүдийн эдийн засгийн бодит байдлын үзүүлэлтүүд, зөв зураглалыг харуулах талаар олон шинэ концепци, системүүдийг зохиож эхэллээ.

Нөгөө талаар дэлхийн эдийн засгийн эдүгээгийн ба ойрын ирээдүйн хүндрэлтэй байдал нь гадаад сөрөг хүчин зүйлүүдийн зэрэгцээгээр эдийн засгийн дотоод бодит орчны тухай статистик өгөгдлүүдүүд мэдээллүүд хомс, тэдгээрт тулгуурлан хийсэн олон анализ дүгнэлтүүд мөн алдаа, ташаа элбэгтэй байсныг дөнгөж саяхан, дэлхийн эдийн засгийн судалгааны байгууллагууд, эрдэмтэд судлаачид тэмдэглэж байгаа билээ.

Цар тахлын дараах үеийн полиперма кризисийг ихэнх судлаачид эдийн засгийн жирийн мөчлөгийн илрэл бөгөөд хоёр гурван жилийн дараа дэлхийн эдийн засаг бараг аяандаа сэргэнэ хэмээн тооцоолсон байдаг. Ер нь судлаачид сүүлийн жилүүдэд дэлхийн

даяар тархаж буй шинэ үзэгдлүүд: гадаад харилцаа, худалдаанд гарч буй өөрчлөлтүүд, ялангуяа бүтцийн өөрчлөлтүүд, эрэлтийн хомсдол тун удалгүй нийлүүлэлтийн хангалтгүй байдал руу шилжиж буй болон санхүүгийн зах зээл тусгаарлагдмал, хэт эмзэг болсон зэргийг олж харж, таамаглаж чадсангүй.

Мөн тэргүүлэгч, хүчирхэг улс орнууд ч эдийн засгийн, олон улс хоорондын харилцааны ба бүтцийн өөрчлөлт, динамикийн онцлогийг ажиглаж чадсангүй. Энэ хугацаанд Америк дотоод зах зээлээ хамгаалах бодлогоо үргэлжлүүлж, Англи улс санхүүгийн хүндрэлд автагдаж, ерөнхий сайдаа огцруулсан, Германд аж үйлдвэрийн хямарл гүнзгийрсэн болон Орос Украины дайнаас шалтгаалан нийлүүлэлтийн хомсдол гүнзгийрч, олон улсын төлбөрийн системд өөрчлөлт орсон зэргийг бүрэн тооцоолж чадаагүй ажээ.

2024 оны эхний саруудад Холбооны нөөцийн банкны тэргүүн: “бодлогын хүүгээ бууруулахыг яарахгүй, инфляци багассан гэсэн баттай дата мэдээллүүд хараахан гараагүй” гэсэн хэт болгоомжилсон байр суурийг илэрхийлсээр байв. Эдгээр бүхэн дэлхий даяар эмпирик судалгаа маш чухал бөгөөд эдийн засгийн загварчлал тооцооллын үйл ажиллагаанд хиймэл оюуныг ашиглах явдал хангалтгүй, дутмаг байгаагийн нотолгоо билээ.

Ойрын ирээдүйд дэлхийн улс орнуудын хоорондох эдийн засаг худалдааны харилцаа дахин өөрчлөгдөж, үндэсний макро эдийн засгийн бүтцэд үлэмжхэн нөлөөлөх тул нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад үлэмжхэн анхаарах шаардлага дахин үүснэ. Ер нь ойрын ирээдүйд дэлхийн эдийн засаг глобал харилцаа интеграцид тулгуурласан хэвээр байх бөгөөд улс гүрнүүдийг хооронд нь эдийн засгийн хувьд нягт холбосон ресурс, таваар материалын ба үйлчилгээний урсгал, хэлхээ холбоо чухал үүргийг гүйцэтгэнэ. Харин дэлхийн улс орнуудын хоорондох эдийн засаг худалдааны хэлхээ холбоо нь шинэ хэлбэрээр: мэдээлэл, мэдлэг, шинжлэх ухааны ололтууд болон инновацыг харилцан солилцох урсгалаар баяжиж тэлэх нь дамжиггүй. Мөн дэлхий даяар Америкийн жишээгээр технологийн төвүүд буй болж өндөр технологийн компаниудад хөрөнгө оруулалтын туслалцаа үзүүлж, хөгжил дэвшлийг түргэсгэх шинэ хүчин зүйлүүдийг нэвтрүүлэх төлөвтэй.

Ойрын ирээдүйн шинжлэх ухаан техник, технологийн хөгжил нь эволюци хөгжлийн хүрээнд өмнөх үеийн хөгжил дэвшлийн үргэлжлэл хэлбэрээр үргэлжлэх боловч эдүгээ зөвхөн туршлагын шатанд хэрэгжиж буй олон ололтууд амьдралд, бизнест нэвтрэх магадлалтай. Дэлхийн улс гүрнүүдийн эрчим хүчний бүтцийг өөрчлөхөд үлэмжхэн амжилт гарна. Сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн ерөнхий чиглэл нь нарны, салхины, далайн, гол мөрний, атомын цахилгаан станцуудыг өргөн цар хүрээтэй, төвлөрүүлэн байгуулахын зэрэгцээгээр бага оврын цэвэр эрчим хүчний хэлбэрүүд орон нутагт өргөн дэлгэрэх ажээ. Финляндын туршлагаар маш энгийн боловч өндөр үр ашигтай технологиор элс агуулсан томоохон (100 тн багтаамжтай) сав батареинуудыг бүтээж, нарны энергийг хадгалан ашиглаж орон сууц, жижиг үйлдвэрүүдийн дулааны энергийн хэрэгцээг хангах боломж үүсжээ. Үүний зэрэгцээгээр резистив халаалтын систем хэмээх арга технологи нэвтэрч хөдөө аж ахуй, фермерүүд өргөн ашиглах боломжтой болжээ.

Эрчим хүчний шинэ хэлбэрийн нэгэн болох агаараас түлш үйлдвэрлэх арга амьдралд нэвтрэх нь ээ. Швейцарийн инженер-химичүүд агаарт нэвчсэн ердийн усыг химийн аргаар задалж устөрөгчийн түлш гаргаж чаджээ. Энэхүү төхөөрөмж нь ногоон ургамлын фотосинтез, технологи ажиллагаатай ижил төстэй бөгөөд агаарт тархсан усны молекулуудаас хийн төрлийн устөрөгчийг нарны энергиэр боловсруулах чадвартай, хагас дамжуулагч материалуудыг ашигладаг гэнэ. Мөн Колорадогийн их сургуулийн эрдэмтэд элс, гель болон бактериудыг ашиглан амьд бетон хэмээх шинэ барилгын материалыг бүтээн туршжээ. Энэхүү амьд бетон нь яваандаа үүсдэг цууралт, нүх сүвийг өөрөө нөхөж сэргээх чадвартай учир бетон конструкцийн чанарыг дээшлүүлэх боломжтой болжээ. Мөн агаарын элдэв төрлийн хорт бодисыг өөртөө шингээж устгах болон гэрэлтэх чадвартай бетон үйлдвэрлэж туршжээ.

Техник, технологийн ойрын ирээдүйн нэгэн чиглэл нь нанотехнологийн электроник, шинэ төрлийн материал бүтээх ба эмнэлгийн салбаруудад өргөн ашиглах бат бөх бөгөөд хөнгөн, хиймэл материалуудыг үйлдвэрлэх, шинэ төрлийн электрон техник болон эм тариа, эмнэлгийн нэмэгдэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж олгоно. Нанотехнологи, геномик болон микробиологийн салбаруудад шинэ амжилтууд гарах бөгөөд хувь хүн нэг бүрийн физиологийн онцлогт тохирсон эмнэлгийн тусламж үзүүлэх, хүний генүүдийг редакторлан засварлаж эмчлэх зэрэг шинэ арга эмнэлгийн шинжлэх ухаан, практикт нэвтрэх төлөвтэй.

Мөн хиймэл оюун ухааныг хөгжүүлэх, ашиглахад томоохон амжилтууд гарах бөгөөд хүн нийгмийн алгокогнитив соёл шинэ шатанд дэвшин шилжих, хүмүүсийн бүх төрлийн үйл ажиллагаанд өргөн нэвтрэх зэрэг чиглэлүүд давамгайлах ажээ. Хиймэл оюуны хөгжил дэвшилттэй шууд холбоотойгоор квантын тооцоолол амьдралд нэвтрэх сонгомол компьютерын дижитал ажиллагааны явцад бүтээх боломжгүй олон үйлдлийг гүйцэтгэх чадвар эрс дээшлэх магадлалтай.

Гэхдээ хиймэл оюуныг дэдлхийн улс гүрнүүдийн улс төр, нийгэм эдийн засгийн амьдралд нэвтрүүлэхэд мөн л болгоомжтой хандах шаардлагатай. Хиймэл оюун дэлхий даяар бүх салбарт нэвтэрсэн цагт технологийн байнгын ажилгүйдэл гэгч үзэгдэл гарч болзошгүй. Зарим эдийн засагчийн тооцоогоор бол хорин жилийн дараа дэлхийн эдийн засаг жилийн 10 хувийн өсөлттэй хөгжих боломжтой боловч үүнтэй зэрэгцэн ажилгүйдэл 80 хувь хүрэх ажээ.

Техник технологийн хөгжлийн нэгэн чухал чиглэл нь сансар судлал ба сансрын эдийн засаг байх болно. Дэлхийн эдийн засаг орон зайн хувьд дэлхий ертөнцийн гадаргуугаас хальж, сансар огторгуйг хамарч цар хүрээгээ тэлж, шинэ хэлбэрээр сансрын эдийн засгийн хэлбэрээр хөгжих стратеги ажиглагдана.

Эдүгээ сансрын эдийн засаг нь цар хүрээ ба чанарын эрс өөрчлөлтийн ирмэгт тулж ирсэн хэмээн эрдэмтэд тэмдэглэж байгаа бөгөөд дэлхийн томоохон улс гүрнүүдийн улс төрийн дээд удирдлагуудын сонирхол, анхаалыг ихээхэн татах боллоо.

Эдүгээ сансрын орон зайнд 90 гаруй улс орон үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд сансрын эдийн засгийн хэмжээ 2022 оны байдлаар бараг 500 миллиард долларт хүрчээ. Сансрын эдийн засагт 10000 гаруй фирм 5000 орчим хөрөнгө оруулагчид сансар судлалд өргөн оролцож буйн зэрэгцээгээр бизнесийн ашиг олох арга замыг ч хайж байна.

Сансрын эдийн засаг хөгжихийн хэрээр сансрын тойрог замд ачаа гаргах зардал 95 хувиар хямдарчээ. Ялангуяа сансарт ачаа хөөргөх пуужингуудын хөдөлгүүр хэсгийг олон дахин ашиглах арга нэвтэрсэн нь сансрын эдийн засгийн үр өгөөжийг үлэмжхэн нэмэгдүүлэх боломж олгожээ. Сарны гадаргууг эзэмжих талаар өргөн бөгөөд ширүүн өрсөлдөөн өрнөх төлөвтэй.

Хэрэв Хятад болон Орос улс ойрын ирээдүйд саран дээр атомын цахилгаан станц байгуулж амжвал сансар судлал болон сансрын эдийн засаг улам эрчимтэй хөгжих боломжтой. Европын сансрын агентлагийн мэдээлснээр сансрын шинэ инфраструктурыг хөгжүүлснээр цаг уур амьсгал судлал, эрчим хүч, тээвэр, далайн ба агаарын хөдөлгөөнийг зохицуулах, удирдах болон бусад үйлчилгээнд өргөн ашиглах боломж бүрдэж буй ажээ. Сансар судлал өндөр хурдацтай өргөжиж буйн ачаар манай газар дэлхийн зургийг таван жилийн өмнөхөөс 10 дахин өргөн талбайг хамарсан байдлаар зохиож буй бөгөөд дэлхий даяарх холбооны нэвтрүүлэх чадварыг мөн 10 дахин нэмэгдүүлэх боломжтой болжээ. Хөдөө аж ахуйд ч сансар судлалын мэдээлэл өгөгдлүүдийг өргөн ашиглах, сансраас авсан хөдөө аж ахуйн газар нутгийн өндөр нарийвчлалтай зургийг фермерүүд өргөн ашиглах боломжтой болжээ.

Өнөөгийн дэлхий нийтийн, улс гүрнүүдийн эдийн засгийн хөгжлийн түвшнийг дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) хэмээх үзүүлэлтээр төлөөлүүлэн дүгнэж буй нь эдийн засгийн бодит байдлыг зөв харуулах чадваргүй тул ялангуяа улс гүрнүүдийн улс төрийн дээд удирдлага, элитүүдийг төөрөлдүүлж, алдаатай, буруу шийдвэр гаргуулах аюултай. Дэлхийн ихэнх улс гүрнүүдэд баян ядуугийн ялгаа ихсэх хандлага хэвээр атал статистик үзүүлэлтээр нэг хүнд ногдох ДНБ-ий үзүүлэлт ямагт сайжрах, өсөх, дээшлэх хандлагатай гардаг.

Мөн өнөөгийн ДНБ-ий үзүүлэлтийн аргачлалаар бол цэрэг дайны үйл ажиллагааны хор хөнөөлийг тооцоолох чадавхгүй, зөвхөн цэргийн салбаруудын, ялангуяа цэрэг зэвсгийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх аж үйлдвэрийн нэмэгдсэн өртгийг л харуулах боломжтой. Энэ байдлаас шалтгаалан дайн байлдаанд оролцож буй улс гүрнүүдийн эдийн засаг ДНБ-ий үзүүлэлтээр өсөж хөгжиж буй мэт байдалтай харагддаг. Байгаль орчны, цаг уурын өөрчлөлтийн сөрөг, аюулт үзэгдлүүдийн хор хөнөөлийн тооцооны аргачлал ч төлөвшөөгүй хэвээрээ. Зөвхөн түүний учруулсан хор хөнөөлийн багахан хэсгийг арилгахад зарцуулсан хөдөлмөр зардлыг л ДНБ-ий өсөлтийн тооцоонд хамруулах жишээтэй.

Ойрын ирээдүйд дэлхийн цаг уурын өөрчлөлт ба үүнтэй уялдаатай байгалийн гамшигт үзэгдлүүдийн хор хөнөөлийг багасгахад чиглэгдсэн олон томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх төлөвтэй. Эрдэмтэд манай гариг дэлхий дээр ойрын 5 жилд глобал дундаж агаарын температур аж үйлдвэрийн хувьсгалын өмнөх үеэс 1.5°C градусаар нэмэгдэнэ гэсэн тооцоотой. Эн тэргүүнд дэлхийн улс гүрнүүдийн эдийн засгийн хөгжлөөс шалтгаалсан эрчим хүчний хэрэглээний өсөлтөд цэвэр эрчим хүчний хувийн жинг нэмэгдүүлж, нүүрс хүчлийн хийн ялгарлыг 2030 он гэхэд хоёр дахин багасгах зорилготой.

Эрчим хүчний салбарын шилжилтийг хангахуйц техник технологийг ба арга хэрэгслийн чиг хандлагыг хүн нийгэм ерөнхийдөө шийдвэрлэж чадсан гэж үзэх

үндэслэлтэй. Гагцхүү энэхүү шилжилтэд шаардагдах хөрөнгө оруулалтыг бүрэн хангахуйц мөнгө санхүүгийн нөөцийг бүрдүүлэх шаардлагтай.

Энэ тухай судалгааны “REN-21” байгууллагын тэмдэглэснээр дэлхийн дулаарлыг ойрын ирээдүйд 1.5°C градусаар хязгаарлах зорилтыг хэрэгжүүлэх ажил томоохон эрсдэлтэй тулгарч байгаа ажээ. Уг нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр дэлхийн улс гүрнүүдэд харьцангуй тэгш хуваарилагдсан бөгөөд түүний олон хэлбэрийг эдийн засгийн потенциалгаар хязгаалагдмал орнууд ч хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Эдүгээ дэлхийн хүн амын 80 хувийг эзлэж буй улс орнууд нуурс ба газрын тосны нетто импортлогчид байдаг. Өөрөөр хэлбэл, эрчим хүчний уламжлалт бүтэцтэй орнууд геополитикийн ба бусад хэлбэрийн дарамт эрсдэлд автагдах магадлал асар өндөр гэдгийг харуулна. Харин сэргээгдэх эрчим хүчний хэлбэрүүд асар олон: нарны, салхины, далай тэнгис, ус, гол мөрнүүдийн ба геотермал, биоэнергийн зэрэг эрчим хүчний хэлбэрээр аливаа нэгэн орны хэрэгцээг бүрэн хангах боломжтой.

Сэргээгдэх эрчим хүчний олон улсын агентлагийн дүгнэлтээр бол 2030 он гэхэд дэлхийн цахилгаан энергийн 65 хувийг, 2050 он гэхэд 90 хувийг сэргээгдэх эрчим хүчнээс хангах боломжтой ажээ. Нөгөө талаар сэргээгдэх эрчим хүчний өртөг харьцангуй хямд бөгөөд ядуулаг олон улсад импортыг багасгах, ажиллах хүчний ашиглалтыг сайжруулах, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг багасгахад шууд эерэг нөлөөтэй.

Олон улсын эрчим хүчний агентлагийн тооцоогоор эрчим хүчний уламжлалт салбарууд хумигдахад 2030 он гэхэд 5 сая ажлын байр үгүй болох боловч, цэвэр эрчим хүчний салбарт 14 сая шинэ ажлын байр буй болох ажээ.

Эдүгээ дэлхий даяар хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагаа асар олон хэлбэр төрлөөр илрэх болж, зарим цаг үед өөр хоорондоо нөөц, баялгийг дахин хуваарилах зорилгоор зөрчилдөх, дайн байлдаан өдөөх ба татагдан оролцох, ер нь хүн нийгмийн гол зорилгыг (хамт нийтээрээ, жигд, тогтвортой тэнцвэртэй хөгжих) орхигдуулах хандлагатай болжээ. Энэ байдлаас үндэслэн дэлхийн эдийн засгийн өнөөгийн гол парадигм нь зөвхөн өсгөх нэмэгдүүлэх, тэлэх хэлбэрээр хязгаарлагдаж буй зорилго илэрхийллийг ирээдүйд өөрчлөх, ялангуяа дэлхийн эдийн засгийг хүн нийгмийн сайн сайхны төлөө, хүн нэг бүрийн хөгжлийн төлөө, тогтвортой хөгжүүлэх, эх дэлхийгээ хайрлан хамгаалах зорилтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх шаардлагатай тулгарлаа.

Дэлхийн эдийн засгийн байгууллагууд, эрдэмтэд судлаачид инклюзив баялгийн эдийн засаг хэмээх ойлголт хэлбэрийг ойрын ирээдүйд дэлхий даяар нэвтрүүлэх саналыг боловсруулан сурталчилж эхэллээ (UN Environment Programme, 2023). Үүний гол утга санаа нь эдийн засгийн хөгжилтэй холбоо бүхий олон асуудлыг нийлүүлэн нэгтгэж, нэг чиглэлээр хүн нийгмийн төлөө зориулах дэлхий даяар энх амгалан тайван тогтуун өндөр бүтээмжтэй, нийтэд өгөөжтэй, хангалуун амьдралыг төлөвшүүлэх зорилгоор илэрхийлэгдэнэ.

Өөрөөр хэлбэл, инклюзив (бүтээмжтэй, өгөөжтэй бөгөөд бүх нийтийг хамарсан) баялгийн эдийн засаг нь өнөөгийн эдийн засгийн хөгжил өсөлтийг харуулах (дотоодын нийт бүтээгдэхүүн-ДНБ) үзүүлэлтийн зэрэгцээгээр нэмэлт болгон байгаль дэлхийн, экологийн, нийгмийн, хүний хүчин зүйлүүдээс шалтгаалан бүрэлдэх бодит баялгийн

динамикийг харуулах зорилготой. Инклюзив баялгийн концепцын гол утга санаа нь эдүгээ манай гараг дэлхий дээр амьдарч буй хөдөлмөрийн чадвартай хүмүүс бүгдээрээ, нийтээрээ баялаг бүтээх боломжтой болох ба эх дэлхийнхээ баялгийг багасгаж хороохгүй байхын төлөө хөдөлмөрлөх боломж буй болгоход чиглэгдэнэ (UN Environment Programm, 2023). Харамсалтай нь, манай дэлхийн хүн нийгмийн үлэмжхэн хэсэг нь баялаг бүтээх үйл ажиллагаанд оролцох боломжгүйн зэрэгцээгээр бусдын бүтээсэн баялгийг дахин хуваарилах замаар өчүүхэн хэсгийг хүртэх хэлбэрээр амьдарч байна.

Дэлхийн банкны тооцоогоор хэт ядуурлын түвшин (өдөрт 1 ядуу хүнд 2.15 доллар ногдох хэмжээний) сүүлийн 30 жилд багасах хандлагатай болжээ. Гэхдээ 2020 оны байдлаар дэлхий даяар 730 сая хүн хэт ядуулагийн түвшиндээ үлджээ. Хэрэв инклюзив баялгийн эдийн засгийг бүрдүүлж чадвал “ядуу” хэмээх бүлэгт хамаарагдах хүмүүсийн суурь стандартыг өөрчилж, өдөрт 12 доллар ноогдохоор төлөвлөж буй ажээ (Credit Suisse Research Institute (CSRI), 2023). Энэ нь дэлхий даяар хүмүүсийн амьдралын ойр зуурын хэрэгцээг бүрэн хангахын зэрэгцээгээр хуримтлалд зориулан орлого мөнгөө хэмнэх боломж олгох бөгөөд хамгийн чухал нь хүмүүсийг эргэж ядууралд автагдахаас зайлсхийх баталгаа болно.

IV. ДҮГНЭЛТ

Дэлхийн нийтийн хүн амын амьдралын түвшнийг энэхүү стандартаар дээшлүүлэхэд өнөөгийн дэлхийн жирийн эдийн засгийн өсөлтийг жил бүр 8 хувиас доошгүй хурдцаар арав гаруй жилийн турш өсгөх шаардлагатай ажээ. Инклюзив баялгийн эдийн засгийн бүтэц хэлбэрүүд нь ердийн эдийн засгийнхаас ялгаатай, ихэнх төлөвдөө хүн нийгмийн баялаг үйлдвэрлэх капитал, активуудаас бүрэлдэх бөгөөд эцсийн үр дүн нь зөвхөн эдийн засгийн хөгжил дэвшлийн үзүүлэлтээр хязгаарлагдах бус хүн нийгмийн, хувь хүмүүсийн амьдралын чанарын үзүүлэлтийг сайжруулах болон хүрээлэн буй орчноо хамгаалах, түүний үнэ цэнийг ч дээшлүүлэх зорилготой.

Инклюзив баялгийг бүтээх капитал активуудын хүрээнд эдийн засгийн капитал, байгаль нийгмийн ба хүмүүн капитал активыг хамааруулдаг ажээ. Бүтээмжтэй баялгийн эдийн засгийн үед ч хөгжил, дэвшил өсөлтийн асуудлууд чухал ач холбогдолтой хэвээрээ үлдэх боловч тогтвортой тэнцвэртэй өсөлтийг илүү анхаардаг. Инклюзив эдийн засгийн өсөлт тэлэлтийн хурдац ч өндөр байх боломжтой бөгөөд өсөлт тэлэлтийн ачаар шинэ ажлын байрыг буй болгож ажиллагчид, хөдөлмөрчдийн орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. Энэхүү эдийн засгийн хөгжил дэвшил нь хөрөнгө оруулалтын потенциалыг нэмэгдүүлэн, техник технологийг улам боловсронгуй болгох хандлагатай бөгөөд тогтвортой, тэнцвэртэй үргэлжлэх чадварын ачаар нийт эрэлтийг нэмэгдүүлэх, хүмүүсийн итгэл найдвар, хүлээлтийг хэрэгжүүлэх боломжтой ажээ.

Нийгмийн баялаг бүтээгч капитал активуудаар төлөөлүүлэн эдийн засгийн динамикийг харуулах үзүүлэлтүүдийг 1990 оноос туршиж үзсэн бөгөөд энэхүү өнгөрсөн хугацаанд дэлхий нийтийн бүтээмжтэй баялгийн нийт дүн бараг 50 хувиар өссөн боловч дэлхийн хүн амын өсөлт нь илүү хурдацтай байсан учраас (дэлхийн хүн ам энэ хугацаанд 5.3 миллиардаас 7.7 миллиард болж өссөн) нэг хүнд ногдох үзүүлэлт нь 5 хувиар буурчээ. Энэхүү хугацаанд хүн нийгэм “байгаль” капиталынхаа ерөнхий цар хүрээг бараг 30% багасгаж эдийн засгийн томоохон гарз хохирлыг амссан гэж үздэг ажээ. Хөгжингүй

орнуудын эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өндөр гарсны гол учир шалтгааныг байгалийн ресурсийг хэт дайчлан шавхаж, байгаль капиталынхаа потенциалыг багасгаснаар тайлбарладаг.

Ялангуяа Япон улс байгаль капиталынхаа ерөнхий потенциалыг 70 хувиар багасгаж хохирсон үзүүлэлттэй. Ер нь хүн нийгмийн эдийн засгийн гарз хохирлын үлэмжхэн хэсгийг байгаль капиталын тухай онол практикийн зөв ойлголтгүй байсан болон түүний үйлчилгээ, үр нөлөөг хэт доогуур үнэлж, хүн нийгэм, өөрөө, байгаль дэлхийн бүтэц бүрэлдэхүүний нэгэн хэсэг гэдгийг ухамсарлан ойлгох чадвар болон сэтгэл зүйн үлэмжхэн хоцрогдлоор тайлбарлаж болмоор.

Эрдэмтдийн тооцоолсноор бол хүн нийгэм 1950-аад онд антропоцен үед шилжин орсон бөгөөд энэ үеэс байгалийн ерөнхий нийт баялгийн (хоол хүнс, цэнгэг ус, амьд байгаль, ургамлууд) эрэлт эрс нэмэгдэж, тэдгээрийг байгаль дэлхий нөхөн сэргээх чадваргүй болж эхэлсэн гэж үздэг бөгөөд хүн нийгэм антропоцены үед дэлхийн био орчныг ихээхэн хэмжээгээр доройтуулж, нөхөн сэргээх ажлаа орхигдуулсан ажээ (Colin Neil Waters, 2023). Өөрөөр хэлбэл, дэлхийн II дайны дараах үеийн дэлхийн эдийн засгийн хөгжил дэвшил нь хүн нийгмийн амьдралын түвшнийг эрс дээшлүүлсэн үр дүнтэй боловч үүндээ байгаль дэлхийн ресурс, байгаль капиталын ачаалал, зарлагыг хэт нэмэгдүүлэн, гарз хохирлын нэмэгдсэн үзүүлэлтээр “нөхөн биелүүлсэн” ажээ. Үүнтэй холбогдуулан эдүгээ, байгаль капиталын үнэ цэнийг зөв тооцоолох, тодорхойлох шаардлага гарч байна.

Байгаль, капитал активыг эзэмших болон түүнийг ашиглах боломж хэмээх үйлдлүүд хоорондоо үлэмжхэн ялгаатай.

Байгаль капиталын төрөлд хамаарагдах боловч хэний ч эзэмшилд үл хамаарагдах: дэлхийн агаар мандал, том далайн мандал зэргийг эдийн засгийн тодорхой агент ашиглах бол тэдгээрийн үнэ өртгийг инклюзив баялгийн тооцоонд хамааруулах шаардлага гардаг. Харамсалтай нь, орчин үед байгаль, капиталын үнэ цэнийг эдийн засгийн тооцоонд хамааруулж байгаагүй явдал байгаль дэлхий, хүрээлэн буй орчныг үлэмжхэн доройтолд хүргэсэн билээ.

Агаар мандал хэмээх бүх нийтийн баялгийн тооцооны үнийг агаарт ялгаруулж буй нүүрсхүчлийн давхар ислийн хэмжээгээр төлөөлүүлэн 1 тонныг хасах 200 доллараар бодож улс гүрний үндэсний тооцоонд үнэ цэнт активыг ашигласны төлбөр болгон хамааруулах стандарт дүрэм гарчээ (World Resources Institute, 2015). Энэхүү аргачлал, стандартын утгаар үзвэл, Монгол оронд малын хөлийн татвар нь ДНБ-ий тооцооноос хасагдах буюу байгалийн бэлчээр хэмээх баялаг актив ашигласны төлбөр болон хувирч хасах тэмдэгтэйгээр эдийн засгийн үндэсний тооцоонд хамаарагдах үндэслэлтэй.

Гэхдээ далай тэнгис хэмээх глобал, бүх нийтийн баялгийг олон улс гүрэн ашиглаж (хог хаягдлыг шингээгч, хүн ба ачаа тээврийн усан онгоц хөлгүүдийн явах зам хэлбэрээр) буй боловч, одоохондоо энэхүү үнэ цэнт активын төлбөрийн тооцооны аргачлал, стандарт боловсрогдоогүй хэвээрээ.

Дэлхийн эдийн засгийн өнөөгийн өсөлт хөгжлийн гол хөдөлгөгч хүчин нь үйлдвэрлэлийн капитал байдаг хэмээн орчин үеийн сэтгэлгээгээр тооцдог бөгөөд сүүлийн 30 жилд 1 хүнд ноогдох хэмжээ нь 90 гаруй хувиар өсжээ гэсэн баримт байдаг.

Гэвч инклюзив баялгийн концепцийн судалгаануудаас үзвэл, хүн хэмээх капитал дэлхийн эдийн засгийн хөгжлийн тулгуур хүчин зүйл гэсэн нотолгоо гарчээ. 2019 оны байдлаар дэлхийн инклюзив баялгийн тэн хагас нь хүмүүн хэмээх капитал активаас бүрэлджээ гэсэн тооцоо гарчээ. Дашрамд дурдахад, байгаль капитал активын эзлэх хувийн жин нь 18 орчим хувь байдаг ажээ.

Инклюзив баялгийн эдийн засгийн гол хөдөлгүүр хүчин зүйл нь эдүгээ хүмүүн хэмээх капитал актив болж эхэлснийг бараг бүх судлаач тэмдэглэж байгаа бөгөөд энэхүү капиталын дотоод бүтэц бүрэлдэхүүнд хүмүүсийн боловсролын түвшин, эрүүл мэндийн байдал, амьдралын ерөнхий түвшин, энх амгалан байдал зэрэг үзүүлэлт хамаарагдана.

Инклюзив баялгийн бүрэлдэхүүн хэсэгт нийгмийн капитал актив хэмээх хүчин зүйлийг хамааруулан судалдаг бөгөөд түүнд улс гүрнүүдийн хүн амын хамтран ажиллах чадвар, нэгдэл нягтрал, харилцан итгэлцэх үзэл баримтлал, хүч чадлаа нэгтгэх боломж, хэцүү хүнд, эрсдэлтэй нөхцлийг туулах чадвар, эдийн засгийн тэгш бус байдалтай тэмцэх зохион байгуулалт зэрэг улс төр, нийгмийн болон хүмүүсийн сэтгэл санааны олон илрэл үйлдлүүдийг үнэлж тооцоолон хамааруулдаг ажээ.

Эцэст нь дурдахад, дэлхийн нийт баялаг 2027 онд гэхэд 630 орчим триллион долларын цар хүрээтэй болно гэсэн урьдчилсан тооцоо гарчээ.

V. НОМ ЗҮЙ

Bhattarai, A. (2022 оны May 22). *The Washington Post*. [www.washingtonpost.com:](https://www.washingtonpost.com/business/2022/05/24/davos-economy-inflation/)

<https://www.washingtonpost.com/business/2022/05/24/davos-economy-inflation/>-ээс

Гаргасан

Colin Neil Waters, S. T.-K. (2023). *Executive Summary: The Anthropocene Epoch and Crawfordian Age*. International Commission on Stratigraphy (ICS) Subcommission on Quaternary Stratigraphy.

Credit Suisse Research Institute (CSRI). (2023). *Global wealth report 2023*. Credit Suisse AG, a UBS Group company.

Daniel H. Rosen, L. W. (2023 оны November 13). How America Should React to China's Economic Slowdown. *Blame Beijing and Help Clean Up Its Mess—but Don't Gloat*, хуудсд. <https://www.foreignaffairs.com/united-states/how-america-should-react-chinas-economic-slowdown>.

El-Erian, M. A. (2022 оны November 22). *Not Just Another Recession*.

[www.foreignaffairs.com: https://www.foreignaffairs.com/world/not-just-another-recession-global-economy](https://www.foreignaffairs.com/world/not-just-another-recession-global-economy)-ээс Гаргасан

Jeongmin Seong, O. W. (2022). *Global flows: The ties that bind in an interconnected world*. McKinsey Global Institute.

Rosen, D. H. (2023). *The Plaza Accord was a 1985 agreement among the G-5 nations of France, Germany, the U.K., the U.S., and Japan*.

UN Environment Programm. (2023). *Inclusive Wealth Report 2023: MEASURING SUSTAINABILITY AND EQUITY*. UN Environment Programm.

World Bank Group. (2023). *World Development Report 2023: Migrants, Refugees and Societies*. Washington, DC and Online: World Bank Group.

World Bank Group. (2024). *Global Economic Prospects*. Washington: World Bank Group.
World Bank Group. (2024). *Global Economic Prospects*. Washington: World Bank Group. <https://doi.org/10.1596/978-1-4648-2017-5>

World Resources Institute. (2015). *Policy and Action Standard /Greenhouse Gas protocol/*. World Resources Institute.